

## 4-р хичээл: Үйлчлэл, үйл ажиллагаануудыг төлөвлөх нь

Та энэхүү хичээлийг бүхэлд нь эсвэл богино хэсэгт хуваан зааж болно. Хичээлийг заахдаа тухайн орон нутгийнхаа нөхцөл байдалд болон чуулга эсвэл ангийн ерөнхийлөгчийн зөвлөлийнхөө хэрэгцээ, нас, ойлголтод тохируулаарай.

### ҮЙЛЧЛЭЛ, ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД НЬ АВРАГЧИЙГ ДАГАХАД БИДЭНД ТУСАЛНА

Өсвөр насанд нь Есүс Христийн “мэргэн ухаан, бие хаа өссөөр байсан агаад Бурханы хийгээд хүмүүсийн таалал Түүнд байлаа” (Лук 2:52). Чуулга ба ангийн ерөнхийлөгчийн зөвлөлөөс үйлчлэл ба үйл ажиллагаанууд яагаад чухал талаар ярилцахыг хүс. Тэдгээр нь Аврагчтай илүү адил болоход бидэнд хэрхэн тусалж чадах вэ?

### БИД ЗОРИЛГОТОЙ БАЙЖ, ТӨЛӨВЛӨСНӨӨР ИХ ЭЗЭНИЙ ХҮСЛИЙГ БИЕЛҮҮЛЖ ЧАДНА

Өсвөр үеийнхэнд зориулсан үйлчлэл, үйл ажиллагааны удирдамж-д жагсаасан зарчмуудыг үзэхэд ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүдийг урь. Эдгээр зарчмыг багтаасан үйлчлэл, үйл ажиллагаануудын цөөн хэдэн санаа гаргахад нь туслахын тулд тэднээр **Үйлчлэл, үйл ажиллагааны төлөвлөгөө гаргагчийг** ашиглуул. **Үйлчлэл, үйл ажиллагааны дэлгэрэнгүй төлөвлөгөөг** ашиглан эдгээр үйл ажиллагаанаас нэгийг илүү дэлгэрэнгүй төлөвлөхийг тэднээс хүс. Дараагийн ерөнхийлөгчийн зөвлөлийн хурлаараа хийсэн үйл ажиллагааныхаа талаар болон **Өсвөр үеийнхэнд зориулсан үйлчлэл, үйл ажиллагааны удирдамж** дахь зарчмуудыг хэрэгжүүлснээр хэр амжилттай болсон талаар дүгнэхийг тэднээс хүс.

### НЭМЭЛТ ЭХ СУРВАЛЖ

- Үйлчлэл, үйл ажиллагаануудын санааг [ChildrenandYouth.ChurchofJesusChrist.org](http://ChildrenandYouth.ChurchofJesusChrist.org)-оос авна уу.
- *Ерөнхий гарын авлага: Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд үйлчлэх нь, 20-р бүлэг, ChurchofJesusChrist.org*